

КИНО УРЛАГИЙГ ҮНДЭСЛЭГЧ НЬ АХ ДҮҮ ЛЮМЬЕР  
МӨН ЭСЭХИЙГ ТОДРУУЛАХ НЬ

С.Бэлгүүнзаяа\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант


**Түлхүүр үгс:** кино урлаг, кино мэдээ, хөдөлгөөнт дүрс, кино проектор, кинетоскоп, синематограф, биоскоп

**А**х дүү Луи, Огюст Люмьер нар 1895 оны 12-р сарын 28-нд Парист анхны тасалбартай кино үзүүлснээр хүн төрөлхтний соёл иргэншлийн гайхам нээлт болох кино урлаг үүссэн гэдэг танил түүхийг олон эх сурвалж өгүүлдэг. Гэвч энэ нь кино урлагийн түүхэнд бичигдсэн хөдөлшгүй үнэн баримт бас биш юм.

Кино урлаг, кино бизнес дэлгэцэн дээр биш, харин хайрцагт хийсэн кинонуудаас эхлэлтэй байсан төдийгүй, хэрэв зээ театрт кино гаргасныг л анхдагч хэмээн тэмдэглэх учиртай бол ах дүү Люмьерээс ч өмнө дэлгэцийн кино урлаг олон түмэнд хэдийнээ хүрчихсэн байсан тухай сүүлийн үед судлаачид хэлэлцэх болов. Тиймээс түүхийн хуудаснаас харамсалтайгаар орхигдсон зарим баримтуудыг цуглуулж, кино урлагийн үнэн түүх ба үндэслэгчдийн тухай эл өгүүлэлдээ оруулахыг хичээлээ.

1891 онд АНУ-ын иргэн Томас А.Эдисон, Уильям Диксон нарын зохион бүтээсэн кино проекторын анхдагч кинетоскоп хөдөлгөөнт дүрс үзэх боломжийг үзэгчдэд олгосон юм.

1894 онд А.Эдисон "кинетоскоп" багажаараа 17 секунд орчим үргэлжлэх хөдөлгөөнт зураглалыг хүмүүс төлбөртэй үзүүлдэг байв (Domankiewicz, 2021). Үйлчлүүлэгч нүхтэй хайрцаг руу тонгойж, жижиг боловч маш тод, ойлгомжтой олон үе шаттай хөдөлгөөнт дүрсүүдийг харах нь сонин, содон гайхалтай зүйл байлаа. Энэ кино хайрцгийн ажиллах зарчим нь линз ба цахилгаан чийдэнгийн хооронд хальсан туузыг маш хурдан дамжуулдагт оршиж байв. Уильям Диксон, Эдисон нарын хөдөлгөөнт зураглалууд нь олны гайхширлыг төрүүлсэн хэдий ч басхүү шүүмжлэлийг араасаа дагуулж байлаа. Үзэгчид тэдний хайрцаг дахь өчүүхэн жижигхэн зураглалыг үзэхийн тулд байнга доош тонгойж, хичээнгүйлэн шагайж харах нь төвөгтэйн дээр басхүү чамгүй мөнгө төлж үзэх нь илүүц зүйл, үүний оронд шидэт дэнлүүний шоу, театрт жүжиг үзэх нь илүү дээр гэлцэх болов. Тиймээс Эдисон юуны өмнө цилиндрт бичил гэрэл зураг бичих туршилт хийсэн боловч харамсалтай нь технологи нь бүрэн бүтэлгүйтсэн юм.




Зураг 1. Эдисоны кинетоскоп. “La Nature” сэтгүүл, 1887 он, Парис.

Гэвч Эдисон бууж өгсөнгүй. 1889 онд Парисын үзэсгэлэн дээр тэрээр Францын эрдэмтэн, физиологич, хронофотографч, лабораторийн гэрэл зургийг үндэслэгч, шинжлэх ухааны нэрт эрдэмтэн Этьен-Жюль Маритай уулзсан бөгөөд улмаар тэд богино хэмжээний кино зураг авах камер зохион бүтээж чаджээ. Тухайн жил алдарт хөрөг зураач, гэрэл зурагчин, гэрэл зургийн хавтан үйлдвэрлэгч бизнесийн эзэн Антуан Люмьер Парист болсон Эдисоны кинетоскопийн үзэсгэлэнд оролцож таарсан нь Льюмерийн гэр бүлийнхний хувьд олзуурхууштай зүйл байлаа. Гэртээ Антуан буцаж ирэхдээ Эдисоны концесс эзэмшигчдийн нэгээс авсан төхөөрөмжөөр богино хэмжээний киног хөвгүүддээ үзүүлэв. Тэрээр хөвгүүддээ нүхээр кино хальс үзэх төхөөрөмж болон том хэмжээтэй камер болох кинетографын хямд, хялбар хувилбарыг яаралтай хөгжүүлэхийг хичээх хэрэгтэй гэж чухалчлан зөвлөжээ. **Кинетоскоп** нь зөвхөн нэг үзэгчдэд кино үзүүлэх боломжтой байсан бол эцэг Антуан нь Огюст, Луис хоёрыг олон хүн нэгэн зэрэг үзэх боломжтой, дэлгэцэн дээр кино бүтээх арга дээр шаргуу ажиллахыг уриалсан байна (Pruitt, 2023). Огюст 1894 оны өвөл анхны туршилтуудаа эхлүүлсэн бөгөөд дараа жилийн эхээр ах дүү

хоёр **синематограф** гэж нэрлэсэн өөрсдийн төхөөрөмжөө бүтээжээ. Кинетографаас хамаагүй жижиг, хөнгөн, ойролцоогоор таван кг (11 фунт) жинтэй бөгөөд гар ажиллагаатай хөшүүрэг ашиглан ажилладаг байв. Синематограф нь киноны зургийг секундэд 16 фрэймийн хурдаар авч, дүрсэлсэн нь Эдисоны төхөөрөмжөөс (секундэд 48 кадр) хамаагүй удаан бөгөөд энэ нь ажиллахад чимээ шуугиан багатай, бага хальс ашиглаж байсан гэсэн үг юм. Синематографийн гол шинэлэг зүйл бол камераар дамжуулан хальсыг зөөвөрлөх механизм байв. Луи Люмьер энэ механизмыг оёдлын машины ажиллах зарчимд үндэслэн зохион бүтээсэн байна. Ингээд 1895 онд Луи болон Огюст Люмьер нар Синематографийг өөрсдийн нэр дээр патентлан авчээ. Ингээд 1895 оны 12 сарын 28-нд хамгийн анхны худалдааны зорилготой киног тэд гаргаж байсан бөгөөд энэ нь 20 минут үргэлжлэх 10 тусдаа үйл явдлыг харуулж байжээ. Ийнхүү Францын Люмер овогт Огюст, Луи гэгч ах дүү хоёр ийнхүү 1895 онд Америкийн зохион бүтээгч Томас Альва Эдисоны кинетоскопыг улам боловсронгуй болгон сайжруулж, Парисын Капуцинов хэмээх цэцэрлэгт гудамжинд “Галт тэрэг ирсэн нь”, “Ажилчид үйлдвэрээс гарч байна” хэмээх богино хэмжээний кино үзвэрийг хүмүүст толилуулжээ.

Цаашлаад ах дүү хоёр 1896 оны эхээр Францын өдөр тутмын амьдралыг голдуу зурагласан 40 гаруй киног, тэр дундаа анхны кино мэдээ болох “Францын гэрэл зургийн нийгэмлэгийн бага хурлын бичлэг” болон мөн анхны баримтат кино гэх тодотголтой “Лион гал түймрийн албаны тухай” киног бүтээв. Үүнийгээ

үзүүлэхээр Лондон, Брюссель, Бельги, Нью-Йоркт синематограф театруудыг нээжээ.



*Le cinématographe Lumière: projection.*

Зураг 2. Люмьерийн синематограф ажиллаж байна.

**И**нгэж бусад зохион бүтээгчид, зураглаач, найруулагчдаас урьтаж олон орны хүмүүст өөрсдийн хийсэн богино кинонууд буюу амьдралын дүр зураглалыг үзүүлснээрээ кино урлагийн шавийг тавьсан хэмээх эрхэм алдрыг ах дүү Льюмерүүд авч чадсан билээ. Гэтэл тухайн цаг үед Британид ах дүү хоёроос урьтаж дэлхийн хамгийн анхны кино мэдээ болох “Германы Киелийн сувгийн нээлт”, “Оксфорд-Кембрижийн завины уралдаан”-ыг англи зурагчин Бирт Акрес өөрийн бүтээсэн кинетик камераар авсан байдаг. Гагц тэрээр уг киногоо үзүүлэх багаж үгүй байсан учир 1896 он хүртэл олон түмэнд толилуулж чадаагүй юм.

Бирт Акрес нь Лондонд гэрэл зурагчин мэргэжлээр ажилладаг, үүлний хронофотографийн судалгааг өөрөө туршиж үзсэн авьяаслаг зурагчин байв. 1894 оны 12-р сард

Эдисоны кинетоскопын хуулбарыг үйлдвэрлэж байсан инженер, багаж үйлдвэрлэгч Роберт Пол түүнд хандаж, хамтдаа кино камер бүтээхийг санал болгожээ. Акресийн гэрэл зургийн туршлага үүнд нэмэр болно гэж тэрээр үзсэн нь дамжиггүй. Үнэхээр ч түүний туршлага хэрэг болж тэд амжилттай кинетик камераа бүтээж чадав.



Зураг 3. Бирт Акрес 1895 оны 5-р сарын 29-нд Элсом дахь Дербигийн тэмцээнийг бичиж буй нь.

Төдөлгүй 1895 оны 2-р сар гэхэд анхны кино туршилтаа хийж, өөрсдийн найз *Хенри Шортыг крикетийн цагаан өмсгөл өмсөж Барнет дахь Кловелли зуслангийн гадаа алхаж байхыг* харуулсан бичлэгийг хийсэн байна. Энэхүү нэргүй туршилтын кино нь хэзээ ч худалдаанд гарч байгаагүй бөгөөд үнэндээ Британийн анхны кино бүтээл байсан юм. 1895 оны 6-р сар хүртэл Акрес, Пол нар дараагийн бүтээлүүдээ хийсээр байлаа. Үүнд “Оксфорд, Кембрижийн завины уралдаан”, “Довер дахь ширүүн тэнгис”, “Халаасны хулгайчийг баривчилсан нь”, “Мужааны дэлгүүр”, “Боксын Кенгуру” гэх кинонууд байв. Харин 1895 онд хийгдсэн “Дерби” хэмээх кино нь Акрес, Пол хоёрын хамтдаа бүтээсэн хамгийн сүүлийн кино байсан бөгөөд хувь хүний хувьд огт таарч тохирохгүй байсан эрхмүүд тухайн оныхоо 7-р

сард хоёр тийш болж, тус тусын зам мөрийг хөөж, өөрийн бие даасан киногоо хийцгээх болов. Ингэж хамтын хүчээ сарниулсан нь тэдний хувьд анхны кино мэдээгээ дэлхий дахинд үзүүлэх боломжоо алдсан байж ч мэдэх юм. Ганцаар ажиллах болсон Акрес 1895 оны 6-р сард Герман руу аялж, Киел сувгийн нээлт зэрэг хэд хэдэн үзэгдлийн зураг авалтыг амжилттай хийж ирсэн бөгөөд түүнийгээ үзэгчдэд үзүүлэхийг ихэд яарч байв. Гэвч кино проекцын ажил нь жилийн дараа л жигдэрч 1896 оны 1-р сарын 10-нд Их Британий Лиондоун гэрэл зургийн клубт анх удаа үзэгчдэд өөрийн киногоо үзүүлжээ.

**А**х дүү Льюмерийг кино урлагт анхдагч гэдгийг няцаах дараагийн нэг баримт бол Германы зохион бүтээгч, кино найруулагч Макс Складановский болон түүний ах Эмилийнхээ хамтаар бүтээсэн “Биоскоп” кино проектор юм. Тэд проектороо “биоскоп” гэж нэрлэсэн нь учиртай. Энэ нь Грекийн “*bios*”- амьдрал, “*skopeein*”-харах гэсэн үгнээс гаралтай бөгөөд “*амьдралыг харах, судлах*” гэсэн гүн ухааны ойлголт (ElectricPalaceHarwich, 2021) нь ах дүү хоёрын шинэ нээлтийн нэр болж үлджээ. Чухамдаа тэдний чин хүсэл нь олон хүмүүсийг нэг дор цуглуулж, өөрсдийн бүтээсэн киног том дэлгэцээр гаргаж, хэн бүхний харааг кино бүтээлдээ чиглүүлэхийг ихэд хүсэж байлаа. Тэдний зорилго ч биелж 1895 оны 11-р сарын 1-нд буюу *Ах дүү Льюмер олон нийтэд зориулсан анхны кино төслөө Парисын Гранд кафе*д үзүүлэхээс бараг хоёр сарын өмнө хөдөлгөөнт зургийн шоугаа Берлиний Төв зочид буудлын Өвлийн цэцэрлэгийн бүжгийн танхимд төлбөр-

тэйгөөр үзэгчдэд үзүүлж байжээ (Barber, 2010).



Зураг 4. 1895 оны 11-р сарын 1-нд гарах киноны зар.

Тэд кино зураг авалтаа Берлиний аж үйлдвэрийн хойд хэсэгт, үйлдвэрийн ажилчид ихээр суурьшдаг, тэр дундаа шар айрагны олон үйлдвэртэй, хүн ам асар их Пренцлауэрберг, Панков зэрэг орон сууцны хороололд уран бүтээлийн урлан түрээсэлж хийдэг байв. Анхны киноны зураг авалтаа тус хорооллын үйлдвэрийн яндангийн панорама болон сүм хийдүүдийн барилгуудын ур хийцийг авсан байдаг. Ийнхүү аялал жуулчлал, танин мэдэхүй, урлаг гоо зүйн чанартай хөдөлгөөнт дүрслэлийг ах дүү хоёр анх авч байжээ. Ийм зураг авалтын техник, кадрын агууламж, өнөөг хүртэл зураглаачид ашигласаар л байна. Харамсалтай нь тэд дэлхийн хамгийн анхны кино бүтээгчид гэж алдаршиж чадаагүй нь санхүүгийн нөөц боломж, цаг үеийн нөхцөл байдал мөн хурд шандас, сүйхээ дутагдсаных биз. Дээр өгүүлсэнчлэн кино урлагийг түүчээлэгчдийн хувьд ч 1895 оны 11-р сарын 1-нд Берлинд анхны хөдөлгөөнт зургийн шоуг Биоскоп ашиглан хийсэн ах дүү Складановскийн адилаар зохион бүтээх авьяас, хүсэл тэмүүлэл байсан ч гагц санхүүгийн нөөц, хамтын хүч, хамгийн гол нь дэмжлэг дутмаг байсан нь тодорхой. Харин “Ах дүү Льюмерын

амжилтад хүргэсэн гол нууц нь авхаалж самбаа, хурд хүч, тэвчээр хатуужил, санхүүгийн дэмжлэг түүн дээр нэмээд аз од байсан” (PRUITT, 2023).

**Э**цэст нь өгүүлэхэд шинжлэх ухаан техникийн ололт дээр тулгуурлан үүссэн кино урлаг нь дан ганц Льюмерын гэр бүлийн нээлт бус олон судлаач эрдэмтэн, зохион бүтээгчийн алдаа, онооны дэнс дээр суурилсан амжилт байсан нь харагдаж байна. Кино бусад урлагийн төрөл дундаас хамгийн орой мэндэлсэн ч гэлээ асар хурдтайгаар хөгжиж, бүхий л урлагийн төрлүүдийн нэгдэл болж, цөөн жилийн дотор хүн төрөлхтнийг байлдан дагуулж чадсан. Эхлээд дуугүй байснаа дуутай, хар цагаан байснаа өнгөтэй, өргөн формат 35мм байснаа 70мм-ийн хальс, дуу нь моно байснаа стерео бүр цаашлаад 3D, 4D шинэ технологи нэвтэрч кино салбарт хувьсал авчирч, хүмүүс кино үзэх бус кинонд дотроо хамт амьдрах, нэг хэсэг нь болох ч боломж хэдийнээ бүрджээ. Тэгвэл энэ кино урлаг гэх гайхам нээлтийг бидэнд авчирсан Томас А.Эдисон, Уильям Диксон, Бирт Акрес, Роберт Пол, ах дүү Складановский нарыг Льюмерын гэр бүлийн адилаар энд цохон тэмдэглэе. Угаас шинжлэх ухааны алив нээлт бүтээлүүд өмнөх судлаачдын эхлүүлсэн жимээс л эхэлж, жим нь зам болон төгөлдөрждөг нь жам юм. Тиймээс энэ кино урлагийг оргилд хүрэхэд анхны жимийг тавьсан хүн бүрийн гавьяаг түүхийн хуудаснаа дурдаж байх нь зүй юм. Түүнчлэн ах дүү Льюмерын алдар гавьяаг энд бас үгүйсгэх учиргүй бөгөөд тэдний бүтээсэн синематограф кино камер нь хүн төрөлхтний танин мэдэхүй, гоо зүй, зугаа цэнгэлийн ноён оргил кино театрын (cinema) нэр

болон даяар түгж, цар хүрээ хөгжил дэвшил нь цаашид улам төгөлдөржин буй нь гайхам бөгөөд бахархам билээ.

#### Эшлэл

1. Barber, S. (2010). The Skladanowsky Brothers: The Devil Knows. *Senses of Cinema*.
2. Domankiewicz, P. (2021). In the beginning: Cinema's murky origin story. <https://www.bfi.org.uk/sight-and-sound/features/origins-cinema-early-inventors-pioneers>.
3. ElectricPalaceHarwich. (2021). What's a Bioscope show? <https://medium.com/electricpalaceharwich/whats-a-bioscope-show>.
4. Pruitt, S. (2023). The Lumière Brothers, Pioneers of Cinema. <https://www.history.com/news/the-lumiere-brothers-pioneers-of-cinema>.
5. PRUITT, S. (2023). The Lumière Brothers, Pioneers of Cinema. <https://www.history.com/news/the-lumiere-brothers-pioneers-of-cinema>.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Peter Domankiewicz (27 February 2021) In the beginning: Cinema's murky origin story <https://www.bfi.org.uk/sight-and-sound/features/origins-cinema-early-inventors-pioneers>
2. Pruitt, Sarah (June 1, 2023). "The Lumière Brothers, Pioneers of Cinema". HISTORY. <https://www.history.com/news/the-lumiere-brothers-pioneers-of-cinema>
3. <https://filmmongolia.gov.mn/mn/history/mongoliin-kino-urлагiin-hogjiin-ue-1/>
4. Edison's kinoscope. From La Nature, 1887, Paris. <https://www.alamy.com/edisons-kinoscope-from-la-nature-1887-paris-image481926850.html>
5. The Lumière's "Cinematograph" in action [https://www.dpma.de/english/our\\_office/publications/milestones/inventionsthatmadehistory/lumiere/index.html](https://www.dpma.de/english/our_office/publications/milestones/inventionsthatmadehistory/lumiere/index.html)

6. Stephen Barber. Senses of Cinema (October 2010) “The Skladanowsky Brothers: The Devil Knows”
7. Electric Palace Harwich (Mar 3, 2021) What’s a Bioscope show? <https://medium.com/electricpalaceharwich/whats-a-bioscope-show>

### Summary

Many sources tell familiar stories of the birth of cinema, a remarkable breakthrough in human civilization when brothers Louis and Auguste Lumière showed

the first ticketed film in Paris on December 28, 1895. But this is not an immovable fact recorded in the history of cinema. Not only did the cinematography and the film business began with films in boxes, not on screens, but screen cinematography had already reached the masses even before the Lumière brothers. In this article, the author argued Louis and Auguste Lumières’ are the founders of cinematography.

**Keywords:** film art, film news, motion picture, film projector, kinoscope, cinematography, bioscope.